



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/276

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 тоот тогтоолоср баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам” -ын 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.6, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг”-ийн 2020 оны 09 дугаар сарын 18-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг “Мандал дэвжин бадрах” ХХК-ий “Эх булаг” хүнсний дэлгүүр архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглосон өдөр согтууруулах ундаа худалдаалсан зөрчил гаргасан тул “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл”-ийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлсүгэй

2. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн аж ахуйн нэгжид мэдэгдэж, зөрчил дутагдлаа арилгаж, үйл ажиллагаагаа сайжруулсан тохиолдолд дахин зөвшөөрөл олгох ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэхийг “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих” ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Р.Энхтуул/-д даалгасугай.

3. Тусгай зөвшөөрөл нь түдгэлзсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа А.Энхбат, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баттүвшин нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ